

**ОРЛОГЫН ТАТВАРЫГ ДАВХАРДУУЛЖ НОГДУУЛАХГҮЙ
БАЙХ, ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ ЯВДЛААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газар,

Орлогын татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Хэлэлцээр байгуулахыг эрмэлзэн,

Дараах зүйлийг Хэлэлцэн тохиров. Үүнд:

1 дүгээр зүйл.

Хамрагдах этгээд

1. Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч хоёр улс буюу тэдгээрийн аль нэгний байнга оршин суугч этгээдэд хамаарна.

2 дугаар зүйл.

Хамрагдах татварууд

1. Хэлэлцэн тохирогч улс, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс орлогод ногдуулж буй татварууд нь тэдгээрийг хэрхэн ногдуулж байгаа хэлбэрээс үл шалтгаалан энэхүү хэлэлцээрт хамаарна.

2. Орлогод ногдуулж буй татвар гэж нийт орлого болон орлогын бүрэлдэхүүн хэсэгт ногдуулж буй бүх төрлийн татвар түүний дотор хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын орлогод ногдуулах татварыг хэлнэ.

3. Энэхүү Хэлэлцээр нь дараах татваруудыг хамаарна:

а) Монгол Улсын хувьд:

- i/ хүн амын орлогын албан татвар,
- ii/ аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар,
(цаашид "Монголын татвар" гэнэ)

б) Сингапур Улсын хувьд:

- i/ орлогын албан татвар
(цаашид "Сингапурын татвар" гэнэ)

4. Энэхүү Хэлэлцээр нь одоо хэрэглэгдэж буй татваруудтай адил буюу тэдгээртэй үндсэндээ төстөй бөгөөд энэ хэлэлцээрт гарын үсэг зурсанаас хойш тэдгээрийн оронд шинээр бий болсон эсвэл нэмэлт байдлаар ногдуулсан татваруудад мөн адил хамаарна. Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд нь өөрсдийн холбогдох татварын хуулиудад орсон аливаа зарчмын өөрчлөлтийн талаар бие биедээ харилцан мэдэгдэнэ.

3 дугаар зүйл.

Ерөнхий тодорхойлолт

1. Энэхүү Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол доорх нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

а) "Хэлэлцэн тохирогч улс" болон "Хэлэлцэн тохирогч нөгөө улс" гэж тухайн заалтын утгаас хамааран Монгол эсвэл Сингапур Улсыг хэлнэ;

б) "Монгол" гэж газар зүйн утгаар авч үзвэл, Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хэлнэ;

в) "Сингапур" гэж Бүгд Найрамдах Сингапур Улсыг хэлнэ;

г) "этгээд" гэж хувь хүн, компани болон аливаа бусад этгээдийг хэлнэ;

д) "компани" гэж татварын утгаараа аж ахуйн нэгж хэмээн тооцогдох аливаа этгээд, аж ахуйн нэгжийг хэлнэ;

е) "Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгж" буюу "Хэлэлцэн тохирогч нөгөө улсын аж ахуйн нэгж" гэж Хэлэлцэн тохирогч улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгж буюу Хэлэлцэн тохирогч нөгөө улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгжийг хэлнэ;

ё) "харъяат" гэж

- i) Хэлэлцэн тохирогч улсын харъяат иргэн
- ii) Хэлэлцэн тохирогч улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн дагуу өөрийн статус бүхий аливаа хуулийн этгээд, нөхөрлөл эсвэл ассоциацийг хэлнэ;

ж) "олон улсын тээвэр" гэж Хэлэлцэн тохирогч аль нэг улсад голлох удирдлага нь байрладаг аж ахуйн нэгжийн хийж буй усан онгоц болон нисэх онгоцны тээврийн аливаа үйл ажиллагааг хэлнэ. Харин Хэлэлцэн тохирогч нөгөө улсын газар нутаг доторхи байрлалуудын хооронд усан онгоц болон нисэх онгоцоор хийх тээврийн үйл ажиллагаа үүнд үл хамаарна;

з) "эрх бүхий байгууллага" гэж,

- i) Монгол Улсын хувьд Санхүү, эдийн засгийн сайд буюу түүний эрх олгосон төлөөлөгчийг хэлнэ;

- ii) Бүгд Найрамдах Сингапур Улсын хувьд Сангийн сайд буюу түүний эрх бүхий төлөөлөгчийг хэлнэ.

2. Энэхүү хэлэлцээрт тодорхойлоогүй аливаа нэр томъёог хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол, Хэлэлцэн тохирогч улсын тухайн үед хэрэглэгдэж буй хэлэлцээрт хамрагдаж буй татвартай холбогдол бүхий хуульд заасан утгаар ойлгоно. Хэлэлцэн тохирогч улсад тухайн үед хэрэглэгдэж буй татварын хуулиудад заасан нэр томъёоны утга нь Хэлэлцэн тохирогч тухайн улсад мөрдөгдөж буй бусад хуулиудад заасан утгатай зөрчилдөж байвал татварын хуульд заасныг баримтлана.

4 дүгээр зүйл.

Байнга оршин суугч

1. Энэхүү Хэлэлцээрт "Хэлэлцэн тохирогч улсын байнга оршин суугч" гэж тухайн улсын хуулийн дагуу оршин сууж, амьдарч буй, тэр улсад голлох удирдлага нь байрлаж байгаа болон адилтгах бусад шалтгаанаар тухайн улсад татвар төлөх үүрэгтэй аливаа этгээдийг хэлнэ. Энэ нь мөн тухайн улс түүний засаг захиргааны нэгж, орон нутгийн байгууллагуудыг мөн хамрана.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу Хэлэлцэн тохирогч хоёр улсын аль алинд нь байнга оршин суугч этгээдийн статусыг дараахь байдлаар тодорхойлно.

а) байнга амьдардаг орон гэр нь Хэлэлцэн тохирогч аль улсад байгаагаар нь тэр улсад байнга оршин суугч гэж тооцно; хэрэв уг этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэртэй бол Хэлэлцэн тохирогч аль улсад түүний хувийн ба эдийн засгийн харилцаа (язгуур эрх ашгийн төв) нь илүү ойр дөт байгаагаар нь тэндхийн байнга оршин суугч гэж үзнэ.

б) хэрэв түүний язгуур эрх ашгийн төв бүхий улсыг тодорхойлох аргагүй, эсвэл энэ хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэргүй бол хэвшмэл байдалтайгаар оршин амьдардаг Хэлэлцэн тохирогч улсын байнга оршин суугч гэж үзнэ.

в) хэрэв тухайн этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр улсын аль алинд нь хэвшмэл байдлаар оршин амьдардаг, эсвэл алинд нь ч хэвшмэл байдлаар оршин амьдардаггүй бол түүнийг Хэлэлцэн тохирогч аль улсын харъяат байгаагаар нь тэр улсад байнга оршин суугч гэж үзнэ.

г) бусад бүх тохиолдолд Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд асуудлыг хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу хувь хүнээс бусад хуулийн этгээд Хэлэлцэн тохирогч хоёр улсын аль алинд нь байнга оршин суудаг бол түүний голлох удирдлага нь Хэлэлцэн тохирогч аль улсад байрлаж байгаагаар нь тэр улсын байнга оршин суугч гэж үзнэ.

5 дугаар зүйл.

Төлөөлөгчийн газар

1. Энэхүү Хэлэлцээрт "Төлөөлөгчийн газар" гэж аж ахуйн нэгж өөрийн үйл ажиллагаагаа бүхэлд нь буюу хэсэгчлэн явуулдаг бизнесийн байнгын байрлалыг хэлнэ.

2. "Төлөөлөгчийн газар" гэдэгт ;

а) аж ахуйг удирдан явуулж буй газар,

б) салбар байгууллага,

в) албан контор,

г) үйлдвэр, завод,

д) цех, тасаг,

е) уурхай, газрын тос буюу байгалийн хийн цооног, ил уурхай буюу ашигт малтмал олборлож буй бусад газар,

3. "Төлөөлөгчийн газар" гэдэгт мөн:

а) 6 сараас дээш хугацаагаар үргэлжлэх барилгын талбай, барилга байгууламж, угсралт буюу суурилуулалтын ажил түүнд тавих удирдлагын үйл ажиллагаа

б) аж ахуй нэгж өөрийн ажилчдаараа буюу тухайн асуудал хариуцсан бусад ажилтнуудаараа дамжуулан гүйцэтгэж байгаа аливаа 12 сарын дотор нийт дүнгээр 6 сараас дээш хугацаагаар үргэлжлэх үйлчилгээ /зөвлөх үйлчилгээг оруулна/

4. "Төлөөлөгчийн газар" гэдэгт дараах үйл ажиллагааг үл хамруулна.
Үүнд:

а) аж ахуйн нэгж өөрийн бараа буюу эд агуурсыг хадгалах, үзүүлэх, нийлүүлэх зорилгоор байгууламжийг ашиглах;

б) аж ахуйн нэгж өөрийн бараа буюу эд агуурсын нөөцийг зөвхөн хадгалах, үзүүлэх, нийлүүлэх зорилгоор байлгах;

в) аж ахуйн нэгж өөрийн бараа буюу эд агуурсын нөөцийг өөр аж ахуйн нэгжээр зөвхөн боловсруулалт хийлгэх зорилгоор байлгах;

г) аж ахуйн нэгж нь өөртөө зориулан бараа, эд агуурс худалдан авах эсвэл мэдээлэл цуглуулах зориулалтаар байнгын ажлын байртай байх,

д) аж ахуйн нэгж нь өөртөө зориулан бэлтгэх буюу туслах шинж чанартай үйл ажиллагаа явуулах зорилгоор байнгын ажлын байртай байх,

5. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг үл харгалзан 6 дугаар заалтад хамрагдах эрх бүхий бие даасан төлөөлөгчөөс бусад этгээд Хэлэлцэн тохирогч улсад Хэлэлцэн тохирогч нөгөө улсын аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулан, гэрээ хэлцэл байгуулах эрхийг тогтмол эдэлдэг бол уг аж ахуйн нэгжийг Хэлэлцэн тохирогч улсад төлөөлөгчийн газартай гэж үзнэ. Харин уг этгээдийн үйл ажиллагаа 4 дүгээр заалтад дурдсан үйл ажиллагаагаар хязгаарлагдан улмаар тус үйл ажиллагаа явуулж буй байр нь дээрх заалтын дагуу төлөөлөгчийн газар болж чадахгүй тохиолдолд уг аж ахуйн нэгжийг төлөөлөгчийн газартай гэж үзэхгүй.

6. Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө улсад тогтмол үйл ажиллагаа явуулдаг брокер, ерөнхий төлөөлөгч болон бие даасан эрх бүхий бусад төлөөлөгчөөр дамжуулан үйл ажиллагаа явуулдаг бол тухайн аж ахуйн нэгжийг Хэлэлцэн тохирогч нөгөө улсад төлөөлөгчийн газартай гэж үзэхгүй.

7. Хэлэлцэн тохирогч улсад байнга оршин суудаг аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө улсад байнга оршин суудаг, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө улсад үйл ажиллагаа (төлөөлөгчийн газраар дамжуулах буюу бусад аргаар) явуулдаг аж ахуйн нэгжийг хянадаг эсвэл хяналтад байдаг нь тухайн аж ахуйн нэгжүүдийг бие биеийнх нь төлөөлөгчийн газар гэж үзэх үндэс болохгүй.

6 дугаар зүйл.

Үл хөдлөх хөрөнгийн орлого

1. Хэлэлцэн тохирогч улсад байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө улсад байрладаг үл хөдлөх хөрөнгөөс олсон орлогод (хөдөө аж ахуй болон ойн аж ахуйгаас олсон орлогыг оролцуулан) Хэлэлцэн тохирогч нөгөө улсад татвар ногдуулж болно.

2. "Үл хөдлөх хөрөнгө" гэдгийг тухайн хөрөнгө байрлаж буй Хэлэлцэн тохирогч улсын хуульд заасны дагуу тодорхойлно. Аль ч тохиолдолд, уг нэр томъёонд үл хөдлөх хөрөнгөд дагалдах өмч, мал, хөдөө аж ахуйн болон ойн аж ахуйд ашиглагдаж буй тоног төхөөрөмж, газарт суурилагдсан хөрөнгөтөй холбоотой ерөнхий хуулийн заалтын дагуу олгогдсон эрх, бусдын үл хөдлөх хөрөнгийг эзэмшин ашиглах эрх, ашигт малтмалын нөөц, байгалийн бусад баялгийг ашигласны төлөө буюу ашиглах эрхийг оруулна. Харин усан онгоц болон нисэх онгоц үл хөдлөх эд хөрөнгөд үл тооцогдоно.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалт нь үл хөдлөх хөрөнгийг шууд ашиглах, бусдад түрээслүүлэх, эсвэл бусад аль ч хэлбэрээр ашиглах замаар олсон орлогод хамаарна.

4. Энэхүү зүйлийн 1 болон 3 дугаар заалт нь аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгө, түүнчлэн бие даасан хувийн үйлчилгээ үзүүлэхэд ашигласан үл хөдлөх хөрөнгөөс олсон орлогод хамаарна.

7 дугаар зүйл.

Аж ахуйн үйл ажиллагааны ашиг

1. Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө улсын нутагт байрладаг төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлээгүй тохиолдолд уг аж ахуйн нэгжийн ашигт зөвхөн Хэлэлцэн тохирогч улс татвар ногдуулна. Хэрэв аж ахуйн нэгж нь дээр дурдсан байдлаар үйл ажиллагаа эрхэлж байвал уг аж ахуйн нэгжийн ашгийн зөвхөн тухайн төлөөлөгчийн газарт шууд буюу шууд бусаар хамаарах хэсэгт Хэлэлцэн тохирогч нөгөө улс татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө улсын нутагт байрладаг өөрийн төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй тохиолдолд уг төлөөлөгчийн газар нь төлөөлж буй аж ахуйн нэгжтэйгээ бүрэн бие даасан байдлаар харьцан адил, эсвэл төстэй үйл ажиллагааг, адил буюу төстэй нөхцөлд эрхлэн явуулж олж болох байсан ашгийг энэхүү зүйлийн 3 дугаар заалтын дагуу уг төлөөлөгчийн газрын ашиг гэж Хэлэлцэн тохирогч улс бүрийн хувьд тооцно.

3. Төлөөлөгчийн газрын ашгийг тодорхойлохдоо тус төлөөлөгчийн газар бие даасан аж ахуйн нэгж байсан тохиолдолд тухайн Хэлэлцэн тохирогч улсад эсвэл бусад улсад гарч болох байсан хэмжээний гүйцэтгэх болон ерөнхий удирдлагын зардлыг хасч тооцно.

4. Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгж өөрийн салбарууддаа нийт ашгийг хуваарилдаг аргаар төлөөлөгчийн газрын орлогыг тодорхойлж хэвшсэн бол Хэлэлцэн тохирогч улс энэ хэвшсэн аргаар татвар ногдох орлогыг тодорхойлоход энэхүү зүйлийн 2 дугаар заалт ямар ч тохиолдолд саад болохгүй. Гэхдээ хэвшсэн аргаар орлогыг хуваарилсантай холбогдон гарах үр дүн нь энэхүү зүйлд заасан зарчмуудтай зөрчилдөхгүй байвал зохино.

5. Төлөөлөгчийн газар нь харьяалагдах аж ахуйн нэгждээ зориулан зөвхөн бараа, материал худалдан авсаныг үндэслэн уг төлөөлөгчийн газрыг ашиг олсонд тооцож үл болно.

6. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудад нийцүүлэн, төлөөлөгчийн газарт хамаарах ашгийг тодорхойлохдоо өөрчлөх баттай үндэслэлгүй бол жилээс жилд тогтсон нэг аргыг хэрэглэнэ.

7. Хэрэв ашиг нь энэхүү хэлэлцээрийн бусад зүйлд хамрагдах орлогын төрлийг өөртөө агуулсан бол тэдгээр зүйлийн заалтыг мөрдөхөд энэхүү зүйлийн заалтууд үл нөлөөлнө.

8 дугаар зүйл.

Олон улсын тээвэр

1. Усан онгоц болон нисэх онгоцны олон улсын тээврийн үйл ажиллагаанаас олсон ашигт зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага байрладаг Хэлэлцэн тохирогч улсад татвар ногдуулна.

2. Хэрэв усан замын тээврийн аж ахуйн нэгжийн голлох удирдлага нь усан онгоцон дээрээ байрладаг бол энэхүү усан онгоцны харъяалах боомт байдаг Хэлэлцэн тохирогч улсад, хэрэв харъяалах боомт үгүй бол уг усан онгоцны оператор байнга оршин суудаг Хэлэлцэн тохирогч улсад голлох удирдлага нь байрладаг гэж үзнэ.

3. Энэхүү зүйлийн дагуу усан онгоц болон нисэх онгоцны олон улсын тээврийн үйл ажиллагаанаас олсон орлогод дараах орлогыг оруулж тооцно. Үүнд;

а) усан онгоц болон нисэх онгоцыг түрээслүүлж олсон ашиг;

б) бараа, материалыг тээвэрлэх зориулалттай чингэлэгийн (чингэлгийг тээвэрлэх зориулалт бүхий холбогдох тоног төхөөрөмж болон чингэлэг чирэгчийг оролцуулан) ашиглалт, хадгалалт болон түрээсээс олсон ашиг;

гэхдээ дээр дурдсан ашиглалт болон түрээс нь олон улсын усан болон агаарын тээврийн үйл ажиллагаанд ердийн үйл ажиллагаа нь бус, гэнэтийн шинжтэй бол.

4. 1 дүгээр заалт нь аж ахуйн хамсрал (pool), хамтарсан бизнес, болон олон улсын тээврийн ашиглалтын байгууллагын үйл ажиллагаанд оролцож олсон ашигт мөн хамаарна.

9 дүгээр зүйл.

Хоршсон аж ахуйн нэгжүүд

1. Хэрэв:

а) Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө улсын аж ахуйн нэгжийн удирдлага, хяналт болон хөрөнгөд шууд буюу шууд бусаар оролцдог, буюу

б) тухайн этгээдүүд Хэлэлцэн тохирогч улсын болон Хэлэлцэн тохирогч нөгөө улсын аж ахуйн нэгжийн аль алиных нь удирдлага, хяналт болон хөрөнгөд шууд буюу шууд бусаар оролцдог бол,

тэдгээр хоёр нэгжийн хооронд тогтсон худалдаа, санхүүгийн харилцааны нөхцөл нь бие даасан аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцааны нөхцлөөс ялгаатай бөгөөд тухайн аль нэг аж ахуйн нэгжид ногдох ёстой аливаа ашиг

дээрх ялгаатай нөхцлийн улмаас тооцогдоогүй байвал түүнийг уг аж ахуйн нэгжийн ашигт оруулан тооцож зохих журмын дагуу татвар ногдуулж болно.

10 дугаар зүйл.

Ногдол ашиг

1. Хэлэлцэн тохирогч улсад байнга оршдог компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө улсад байнга оршин суугчид төлсөн ногдол ашигт нөгөө улс татвар ногдуулж болно.

2. Гэхдээ ногдол ашиг төлж буй компани байнга оршдог Хэлэлцэн тохирогч улс тухайн ногдол ашигт өөрийн хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулж болох ба гэхдээ ногдол ашиг хүртэгч Хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугч нь түүний жинхэнэ эзэмшигч мөн байх тохиолдолд ногдуулах татварын хэмжээ нь:

а) хэрэв ногдол ашгийн жинхэнэ эзэмшигч нь ногдол ашиг төлж буй компанийн хөрөнгийн дор хаяж 25 хувийг шууд эзэмшдэг компани бол хувьцааны ногдол ашгийн нийт дүнгийн 5 хувиас;

б) бусад бүх тохиолдолд ногдол ашгийн нийт дүнгийн 10 хувиас тус тус хэтрэх ёсгүй. Энэхүү заалт нь тухайн компанийн ногдол ашиг төлөхөөс өмнөх ашигт ногдуулах татварт үл хамаарна.

3. Хэлэлцэн тохирогч улсын байнга оршин суугч компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө улсын Засгийн газарт төлсөн ногдол ашгийг энэ зүйлийн 2 дугаар заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч эхний улсад татвараас чөлөөлнө.

4. Энэ зүйлийн 3 дугаар заалтын "Засгийн газар" гэдэгт

(а) Монгол Улсын хувьд, Монгол Улсын Засгийн газар бөгөөд энэ нь:

(1) засаг захиргааны нэгж

(2) орон нутгийн засаг захиргаа

(3) Монгол Улсын Төв банк (Монгол Банк)

(4) Хэлэлцэн тохирогч хоёр улсын эрх бүхий байгууллагууд хоорондын Хэлэлцэн тохиролцсон Монгол Улсын Засгийн газрын өмчит болон Засгийн газрын өмч давамгайлсан аж ахуйн нэгжийг оруулж тооцно.

(б) Сингапур Улсын хувьд, Сингапур Улсын Засгийн газар бөгөөд энэ нь:

(1) Сингапур Улсын Мөнгөний Удирдах газар болон Валютын Удирдлагын Зөвлөл

(2) Сингапур Улсын Хөрөнгө Оруулалтын Корпораци
(хязгаарлагдмал хариуцлагатай)

(3) Эрх бүхий байгууллага

(4) Хэлэлцэн тохирогч хоёр улсын эрх бүхий байгууллагууд хоорондын Хэлэлцэн тохиролцсон Сингапур Улсын Засгийн газрын өмчит болон Засгийн газрын өмч давамгайлсан аж ахуйн нэгжийг оруулж тооцно.

5. Энэхүү зүйлд, "ногдол ашиг" гэж хувьцааны ногдол ашиг, өрийн нэхэмжлэлээс бусад хэлбэрээр ашигт оролцох эрх болон бусад эрхээс үүсэх орлого мөн түүнчлэн ногдол ашгийн хуваарилалт хийж буй компанийн байнга оршдог Хэлэлцэн тохирогч улсын хуулийн дагуу хувьцааны ногдол ашгийн нэгэн адилаар татварт хамруулдаг аж ахуйн эрхээс олох орлогыг хэлнэ.

6. Хэрэв ногдол ашгийн жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч улсад байнга оршдог бөгөөд ногдол ашиг төлөгч компани байнга оршдог Хэлэлцэн тохирогч нөгөө улсад төлөөлөгчийн газар буюу бие даасан хувийн үйлчилгээ эрхэлдэг байнгын байрлалаар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг ба ногдол ашиг хүртэж байгаа нь хэрэг дээрээ энэ төлөөлөгчийн газар буюу байнгын байрлал байгаатай шууд хамааралтай бол 1 ба 2 дугаар заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 ба 14 дүгээр зүйлийн заалтыг баримтлана.

7. Хэлэлцэн тохирогч улсад байнга оршдог компани хэлэлцэн тохирогч нөгөө улсад ашиг буюу орлого олж байвал нөгөө улс уг компаниас төлж буй ногдол ашигт татвар ногдуулахгүй байж болно. Энэ тохиолдолд гэхдээ тухайн ногдол ашгийг хэлэлцэн тохирогч нөгөө улсад байнга оршин суугчид төлсөн эсвэл ногдол ашиг хүртэж байгаа нь хэрэг дээрээ хэлэлцэн тохирогч нөгөө улсад төлөөлөгчийн газар буюу байнгын байрлал байгаатай шууд хамааралтай бол татвар ногдуулж болно. Харин төлсөн ногдол ашиг эсвэл хуваарилагдахгүй ашиг нь тухайн хэлэлцэн тохирогч нөгөө улсад бий болсон орлого эсвэл ашгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн багтааж байлаа ч тухайн компанийн хуваарилагдахгүй ашиг нь хуваарлагдахгүй ашгийн татварт хамрагдахгүй.

8. Хэлэлцэн тохирогч улсын Засгийн газраас хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугчтай байгуулсан бүтээгдхүүн хуваах гэрээ болон газрын тос, шатдаг хийтэй холбоотой аливаа адитгах гэрээний дагуу олсон орлогыг тараах буюу гадаадад шилжүүлэхэд энэ зүйлийн 2 дугаар заалтыг үл харгалзан хэлэлцэн тохирогч эхний улсад татвараас чөлөөлнө.

9. (а) Одоогийн мөрдөж буй Сингапурын хуулиудын дагуу, ногдол ашгийн жинхэнэ эзэмшигч Монгол Улсын байнга оршин суугчид Сингапур улсын байнга оршин суугч компаниас төлж буй ногдол ашигт тухайн компанийн орлогын албан татвар дээр нэмж Сингапур улс татвар ногдуулахгүй. Ногдол ашгаас хасч буй татвар нь тухайн компанийн ашиг орлогод ногдуулж буй татвар бөгөөд энэ зүйлийн утга агуулгын дагуу ногдол ашигт ногдуулж буй татвар биш юм.

(б) Хэрэв энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсны дараа Сингапур Улс нь өөрийн улсын байнга оршин суугч компанид ашгийн татвараас гадна ногдол ашгийн татвар ногдуулахаар бол тухайн ногдол ашгийн жинхэнэ эзэмшигч Монгол Улсын байнга оршин суугчид ногдуулж буй татвар нь энэ зүйлийн 2 дугаар заалтын дагуу зохицуулагдана.

11 дүгээр зүйл.

Хүү

1. Хэлэлцэн тохирогч улсад бий болж, хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугчид төлсөн хүүд хэлэлцэн тохирогч нөгөө улс татвар ногдуулж болно.

2. Гэхдээ хэрэв хүүгийн жинхэнэ эзэмшигч нь хэлэлцэн тохирогч нөгөө улсад байнга оршин суудаг бол хүү бий болсон хэлэлцэн тохирогч улс өөрийн хуулийн дагуу уг хүүд татвар ногдуулж болох боловч тийнхүү ногдуулах татвар нь:

- (а) хэрэв тухайн хүүг банк болон түүнтэй төстэй санхүүгийн байгууллага авч байгаа бол хүүгийн нийт хэмжээний 5 хувиас,
- (б) бусад бүх тохиолдолд хүүгийн нийт хэмжээний 10 хувиас хэтрэхгүй.

3. 2 дугаар заалтыг үл харгалзан хэлэлцэн тохирогч улсад бий болж хэлэлцэн тохирогч нөгөө улсын Засгийн газарт төлж буй хүүг хэлэлцэн тохирогч эхний улс татвараас чөлөөлнө.

4. 3 дугаар заалтад дурдсан “Засгийн газар” гэдэгт

- (а) Монгол Улсын хувьд, Монгол Улсын Засгийн газар бөгөөд энэ нь:
 - (1) засаг захиргааны нэгж
 - (2) орон нутгийн засаг захиргаа
 - (3) Монгол Улсын Төв банк (Монгол банк)
 - (4) Хэлэлцэн тохирогч хоёр улсын эрх бүхий байгууллагууд хоорондын хэлэлцэн тохиролцсон Монгол Улсын Засгийн газрын өмчит болон Засгийн газрын өмч давамгайлсан аж ахуйн нэгжийг оруулж тооцно.

(б) Сингапур Улсын хувьд, Сингапур Улсын Засгийн газар бөгөөд энэ нь:

- (1) Сингапур Улсын Мөнгөний Удирдах газар болон Валютын Удирдлагын Зөвлөл
- (2) Сингапур Улсын Хөрөнгө Оруулалтын Корпораци (хязгаарлагдмал хариуцлагатай)
- (3) эрх бүхий байгууллага
- (4) Хэлэлцэн тохирогч хоёр улсын эрх бүхий байгууллагууд хоорондын Хэлэлцэн тохиролцсон Сингапур Улсын Засгийн газрын өмчит болон Засгийн газрын өмч давамгайлсан аж ахуйн нэгжийг оруулж тооцно.

5. Энэхүү зүйлд заасан "хүү" гэсэн нэр томъёонд барьцаагаар баталгаажуулсан эсэх, зээлдэгчийн өрийн нэхэмжлэлээс үүссэн орлогод оролцох эрхтэй эсэхийг үл харгалзан, ялангуяа улсын зээллэгээ, бусад үнэт цааснаас орох орлого, мөн тэдгээрийн урамшууллын орлого орно. Харин төлбөр тооцоо хожимдуулсны торгууль нь энэхүү зүйлд дурдсан хүүд тооцогдохгүй.

6. Хэрэв хүү авах эрхийн жинхэнэ эзэмшигч нь хэлэлцэн тохирогч улсад байнга оршдог боловч хэлэлцэн тохирогч нөгөө улсад төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж, тэнд нь энэ хүү бий болж байгаа, эсвэл нөгөө улсад оршдог байнгын байрлалаас хувийн бие даасан үйлчилгээ эрхэлдэг бөгөөд хүү авах эрх нь дурдсан төлөөлөгчийн газар буюу байнгын байрлалтай шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг мөрдлөгө болгохгүй. Энэ тохиолдолд 7 ба 14 дүгээр зүйлийн заалтыг баримтлана.

7. Хүү төлөгч нь тухайн улсын байнга оршин суугч бол хүүг хэлэлцэн тохирогч тухайн улсад бий болсон гэж үзнэ. Гэхдээ хэлэлцэн тохирогч улсын байнга оршин суугч эсэхийг үл харгалзан хүүг төлөгч этгээд нь хэлэлцэн тохирогч улсад төлөөлөгчийн газар, эсвэл байнгын байрлалтай бөгөөд үүнтэй холбогдон хүү төлөгдөж, уг хүү энэ төлөөлөгчийн газарт эсвэл байнгын байрлалд бий болж байгаа бол дээрх төлөөлөгчийн газар, эсвэл байнгын байрлал оршиж байгаа улсад хүүг бий болсон гэж үзнэ.

8. Хэрэв хүү төлөгч болон хүү авах эрхийг жинхэнэ эзэмшигчийн хооронд мөн түүнчлэн тэдгээрийн болон ямар нэгэн хөндлөнгийн этгээдийн хоорондын онцлог харилцаанаас шалтгаалан төлж буй хүүгийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй байсан үед хүү төлөгч болон жинхэнэ эзэмшигч хоёр хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрч байвал энэ зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд хүүгийн

төлбөрийн илүү гарсан зөрүүд хэлэлцэн тохирогч улс бүр өөрийн хуулийн дагуу энэхүү хэлэлцээрийн бусад заалтыг харгалзан татвар ногдуулж болно.

12 дугаар зүйл.

Эрхийн шимтгэл

1. Хэлэлцэн тохирогч улсад бий болж, хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугчид төлж буй эрхийн шимтгэлд хэлэлцэн тохирогч нөгөө улсад татвар ногдуулж болно.

2. Гэхдээ хэлэлцэн тохирогч улсад бий болж байгаа эрхийн шимтгэлд тухайн улсын хуулийн дагуу татвар ногдуулж болох боловч уг эрхийн шимтгэлийг хүлээн авагч нь түүний жинхэнэ эзэмшигч мөн бол ийнхүү ногдуулж буй татвар нь эрхийн шимтгэлийн нийт хэмжээний 5 хувиас хэтрэх ёсгүй.

3. Энэхүү зүйлд хэрэглэгдэж буй "эрхийн шимтгэл" гэсэн нэр томъёонд уран зохиолын хэвлэн нийтлэх эрх, урлаг, уран сайхан болон шинжлэх ухааны бүтээл, түүний дотор уран сайхны кино, буюу радио болон телевизийн нэвтрүүлэгт ашигласан бичлэг буюу кино, патент, барааны тэмдэг болон дизайн, модель, зураг төсөл болон нууц томъёолол буюу процессийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсэн буюу үйлдвэр, худалдаа буюу шинжлэх ухааны туршлагатай холбогдсон мэдээллийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсний төлөө төлж буй бүх төрлийн төлбөр хамаарна.

4. Хэрэв эрхийн шимтгэлийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө улс дахь төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тэнд энэхүү орлого бий болж байгаа эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө улсад оршдог байнгын байрлалаар дамжуулан бие даасан хувийн үйлчилгээ хийдэг түүнчлэн эрхийн шимтгэлийн төлбөр авах эрх буюу хөрөнгө нь хэрэг дээрээ энэхүү төлөөлөгчийн газар эсвэл байнгын байрлалтай шууд холбоотой бол энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 ба 14 дүгээр зүйлийн заалтыг баримтлана.

5. Эрхийн шимтгэл төлөгч нь хэлэлцэн тохирогч улсын оршин суугч бол тухайн эрхийн шимтгэлийг хэлэлцэн тохирогч тус улсад бий болсон гэж үзнэ. Гэхдээ хэлэлцэн тохирогч улсад байнга оршин суудаг эсэхийг үл харгалзан эрхийн шимтгэлийн төлбөр төлөгч этгээд уг Хэлэлцэн тохирогч улсад төлөөлөгчийн газар эсвэл байнгын байрлалаар дамжуулан эрхийн шимтгэлийн төлбөр төлөх үүрэг хүлээдэг бол тэрхүү төлөөлөгчийн газар эсвэл байнгын байрлал оршиж байгаа улсад эрхийн шимтгэлийг бий болсон гэж үзнэ.

6. Эрхийн шимтгэлийн төлбөр төлөх болон авах эрхийг жинхэнэ эзэмшигчид буюу тэдгээрийн болон бусад хөндлөнгийн этгээдийн хоорондын онцлог харилцаанаас шалтгаалан төлөгдсөн эрхийн шимтгэлийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй тохиолдолд түүнийг төлөгч ба жинхэнэ эзэмшигч хоёрын хооронд тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрвэл энэхүү зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан хэмжээнд хамаарна. Энэ

тохиолдолд төлбөрийн илүү гарсан зөрүүд энэхүү Хэлэлцээрийн бусад заалтыг харгалзан Хэлэлцэн тохирогч улс бүр өөрийн хуулийн дагуу татвар ногдуулна.

13 дугаар зүйл.

Хөрөнгийн орлого

1. Хэлэлцэн тохирогч улсын байнга оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө улсад байгаа энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн заалтад хамаарах үл хөдлөх хөрөнгийг худалдаж борлуулснаас олсон орлогод нөгөө улсад татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч нөгөө улсад байгаа үл хөдлөх хөрөнгөнөөс шууд ба шууд бус байдлаар өөрийн үнийн дөрөвний гурваас доошгүйг бүрдүүлж буй Хөрөнгийн Бирж дээр арилжаалагддаг хувьцаанаас бусад хувьцааг борлуулснаас олох Хэлэлцэн тохирогч улсын байнга оршин суугчийн орлогод хэлэлцэн тохирогч нөгөө улс татвар ногдуулж болно.

3. Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд ашиглагддаг хөдлөх хөрөнгийн зарим хэсэг буюу Хэлэлцэн тохирогч улсын байнга оршин суугчаас Хэлэлцэн тохирогч нөгөө улсад бие даасан хувийн үйлчилгээ явуулах зорилгоор ашиглаж буй байнгын байрлалд харъяалагдах хөдлөх хөрөнгийг худалдаж борлуулснаас орох орлого мөн түүнчлэн ийм төлөөлөгчийн газар (дангаар эсвэл бүх аж ахуйн газрын хамт) буюу ийм байнгын байрлалыг худалдаж борлуулснаас орох орлогод нөгөө улсад татвар ногдуулж болно.

4. Олон улсын шугамд ашиглагдаж буй усан онгоц, нисэх онгоц буюу эдгээр усан онгоц, нисэх онгоцны үйл ажиллагаанд хамаарагдах хөдлөх хөрөнгө худалдаж борлуулснаас олсон орлогод ийм тээврийн хэрэгслийг ашиглаж буй тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага байрладаг Хэлэлцэн тохирогч улсад татвар ногдуулж болно.

5. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудад дурдсан хөрөнгөөс бусад хөрөнгийг борлуулснаас орсон орлого нь тухайн хөрөнгийг борлуулагчийн байнга оршин суугч улсад зөвхөн татвар ногдуулна.

14 дүгээр зүйл.

Бие даасан хувийн үйлчилгээ

1. Хэлэлцэн тохирогч улсад байнга оршин суугчаас мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн, эсвэл бие даасан шинжтэй аливаа бусад үйл ажиллагаа эрхлэн олсон орлогод зөвхөн энэхүү Хэлэлцэн тохирогч улсад татвар ногдуулна. Гэхдээ уг орлогод дараахь нөхцөлд Хэлэлцэн тохирогч нөгөө улсад татвар ногдуулж болно.

а) хэрэв байнга оршин суугч нь Хэлэлцэн тохирогч нөгөө улсад өөрийн үйл ажиллагааг явуулахад байнга ашиглаж болох байнгын байрлалтай бол

Хэлэлцэн тохирогч нөгөө улс түүний орлогын зөвхөн байнгын байрлалд хамаарах хэсэгт татвар ногдуулж болно.

б) хэрэв байнга оршин суугчийн Хэлэлцэн тохирогч нөгөө улсад нийт байсан хугацаа нь тухайн хуанлийн жилийн 183 өдрөөс давсан бол Хэлэлцэн тохирогч нөгөө улсад энэ хугацаанд явуулсан үйл ажиллагаанд ногдох орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө улсад татвар ногдуулж болно.

2. "Мэргэжлийн үйлчилгээ" гэж шинжлэх ухаан, уран зохиол, соёл урлаг, боловсрол болон багшлах бие даасан үйл ажиллагаа, түүнчлэн эмч, мэс засалч, хууль, инженер, архитекторч, шүдний эмч болон нягтлан бодогч нарын бие даасан үйл ажиллагааг хэлнэ.

15 дугаар зүйл.

Бие даасан бус хувийн үйлчилгээ

1. Хэлэлцэн тохирогч нөгөө улсад ажил үйлчилгээ эрхлээгүйгээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч улсын байнга оршин суугчийн ажил хийж авсан цалин хөлс болон түүнтэй адитгах бусад орлогод 16, 18 ба 19 дүгээр зүйлд заасанчлан зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна. Хэрэв ажил үйлчилгээг Хэлэлцэн тохирогч нөгөө улсад гүйцэтгэж байгаа бол тэрхүү ажил үйлчилгээнээс олсон орлогод нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө улсад гүйцэтгэж буй ажил үйлчилгээний хөлсөнд олгосон орлогод Хэлэлцэн тохирогч эхний Улсад дор дурдсан нөхцөлд татвар ногдуулна.

а) орлого авагч нь аливаа 12 сарын хугацаанд нийтдээ 183 өдрөөс илүүгүй хугацаагаар Хэлэлцэн тохирогч нөгөө улсад байсан бол, мөн

б) тухайн орлогыг Хэлэлцэн тохирогч нөгөө улсад байнга оршин суудаггүй ажил олгогч өөрөө, эсвэл түүний нэрийн өмнөөс төлсөн бол, мөн

в) тухайн орлогыг ажил олгогчийн Хэлэлцэн тохирогч нөгөө улс дахь төлөөлөгчийн газар буюу байнгын байрлал нь төлөөгүй бол.

3. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудыг үл харгалзан, Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгжээс олон улсын шугамд тээвэр хийж буй усан онгоц болон нисэх онгоцон дээр гүйцэтгэсэн ажил үйлчилгээнд зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн голлох удирдлага нь байрладаг Хэлэлцэн тохирогч улсад татвар ногдуулна. Гэхдээ, хэрэв тухайн орлогыг хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугч төлж байгаа бол тус орлогод хэлэлцэн тохирогч нөгөө улс татвар ногдуулж мөн болно.

16 дугаар зүйл.

Захирлуудын цалин хөлс

Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө улс дахь компанийн Захирлуудын зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагын гишүүний хувьд авсан цалин хөлс болон түүнтэй адитгах бусад орлогод нөгөө улсад татвар ногдуулж болно.

17 дугаар зүйл.

Урлагийн ажилтнууд ба тамирчид

1. Энэхүү Хэлэлцээрийн 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч улсад байнга оршин суугч театр, кино жүжигчин, радио буюу телевизийн жүжигчин, хөгжимчин буюу тамирчин Хэлэлцэн тохирогч нөгөө улсад хувийн тоглолт хийж олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө улсад татвар ногдуулж болно.

2. 7, 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан, урлагийн ажилтан, тамирчны олсон орлого өөрт нь биш бусад этгээдэд ногдож байгаа тохиолдолд уг орлогод тоглолт болсон тухайн Хэлэлцэн тохирогч улсад татвар ногдуулна.

3. Хэлэлцэн тохирогч улсад хийх тоглолтыг хэлэлцэн тохирогч нэг эсвэл хоёр улс болон түүний засаг захиргааны нэгж, орон нутгийн байгууллага, эрх бүхий байгууллага нийтэд нь буюу зарим хэсгийг санхүүжүүлсэн бол энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг үл харгалзан хэлэлцэн тохирогч улсад хийсэн жүжигчид тамирчдын тоглолтын орлогод тухайн жүжигчин болон тамирчны байнга оршин суугаа улсад зөвхөн татвар ногдуулна.

18 дугаар зүйл.

Тэтгэвэр

1. 19 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын дагуу Хэлэлцэн тохирогч улсад байнга оршин суугч этгээдийн урьд хийж байсан ажилтай нь холбоотой олгосон тэтгэвэр болон түүнтэй адилтгах бусад орлогод зөвхөн тухайн улсад татвар ногдуулна.

19 дүгээр зүйл.

Засгийн газрын алба

1.

а) Хэлэлцэн тохирогч улс буюу түүний засаг захиргааны нэгж, эрх бүхий байгууллага, нэгжид алба хашиж байсны хувьд хувь хүнд олгох тэтгэврээс бусад цалин хөлс болон бусад адитгах орлогод зөвхөн тэр улсад татвар ногдуулна.

б) гэхдээ хэрэв уг ажил үйлчилгээг Хэлэлцэн тохирогч нөгөө улсад гүйцэтгэсэн бөгөөд уг хувь хүн нь мөн тэр улсын байнга оршин суугч бол

дараахь тохиолдолд түүнд олгох цалин хөлс болон бусад адитгах орлогод зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө улсад татвар ногдуулна. Уг хувь хүн;

I/ нөгөө улсын харъяат бол,

II/ гагцхүү тухайн албыг хаших үүднээс тэр улсын байнга оршин суугч болоогүй бол.

2.

а) Хэлэлцэн тохирогч улс буюу түүний засаг захиргааны нэгж, эрх бүхий байгууллагад алба хашиж байсны хувьд хувь хүнд Хэлэлцэн тохирогч улс буюу түүний засаг захиргаа, эрх бүхий байгууллага болон түүний бий болгосон сангаас олгосон аливаа тэтгэвэрт зөвхөн тэр улсад татвар ногдуулна.

б) гэхдээ тэтгэвэр авагч нь Хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугч эсвэл тус улсын харъяат бол түүнд олгох тэтгэвэрт зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө улсад татвар ногдуулна.

3. Хэлэлцэн тохирогч улс буюу түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс аж ахуйн үйл ажиллагаа явуулахтай холбоотой алба хашсаны хувьд олгосон цалин хөлс, адитгах бусад орлого болон тэтгэвэрт 15,16 ба 18 дугаар зүйлийн заалтууд хамаарна.

20 дугаар зүйл.

Багш нар болон судлаачид

1. Хэлэлцэн тохирогч улсын их сургууль, коллеж, сургууль, музей болон бусад соёлын байгууллагын урилгаар буюу 2 жил хүртэл хугацаатай соёлын солилцооны албан ёсны хөтөлбөрийн хүрээнд зөвхөн хичээл заах, лекц унших буюу дээр дурдсан байгууллагад судалгаа шинжилгээ хийх зорилгоор Хэлэлцэн тохирогч улсад ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугч байсан буюу байгаа хувь хүний тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг тус улсын гаднаас олсон орлого гэж үзэн хэлэлцэн тохирогч эхний улсад татвараас чөлөөлнө.

21 дүгээр зүйл.

Оюутнууд болон дадлага хийгчид

1. Хэлэлцэн тохирогч улсад ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугч байсан буюу байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч улсад гагцхүү суралцах, дадлага хийх зорилгоор ирсэн оюутан, дадлага хийгчийн өөрийгөө тэжээх, суралцах буюу дадлага хийхэд зарцуулах дараах төлбөр болон орлогыг хэлэлцэн тохирогч эхний улсад татвараас чөлөөлнө.

а) хэлэлцэн тохирогч улсын гаднаас эх үүсвэр нь гарч байгаа төлбөрүүд

б) хэлэлцэн тохирогч аль нэг улсын Засгийн газрын болон шинжлэх ухаан, боловсрол, соёлын мөн ашгийн төлөө бус байгууллагын тусламж, тэтгэлэг болон шагнал

в) тухайн санхүүгийн жилд хэлэлцэн тохирогч улсад хийж гүйцэтгэсэн долоон мянга таван зуун Сингапур доллар (S\$7500) буюу түүнтэй тэнцүү хэмжээний Монгол төгрөгтэй тэнцэх хувийн үйлчилгээнээс олсон орлого

22 дугаар зүйл.

Бусад орлого

1. Хэлэлцэн тохирогч улсад байнга оршин суугчийн аль ч газраас олж буй, энэхүү Хэлэлцээрийн өмнөх зүйлүүдэд тусгагдаагүй аливаа орлогод зөвхөн Хэлэлцэн тохирогч тухайн улсад татвар ногдуулна.

2. Хэрэв орлого ологч нь Хэлэлцэн тохирогч улсын байнга оршин суугч бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө улс дахь төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа буюу Хэлэлцэн тохирогч нөгөө улс дахь байнгын байрлалаар дамжуулан бие даасан хувийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд уг орлоготой холбогдсон эрх ба хөрөнгө нь тус төлөөлөгчийн газар буюу байнгын байрлалтай шууд холбоотой бол 6 дугаар зүйлийн 2 дугаар заалтад тодорхойлогдсон үл хөдлөх хөрөнгийн орлогоос бусад орлогын хувьд энэхүү зүйлийн 1 дүгээр заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 болон 14 дүгээр зүйлүүдийн аль тохирохыг баримтлана.

3. Энэ зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг үл харгалзан, энэхүү хэлэлцээрийн өмнөх зүйлүүдэд тусгагдаагүй хэлэлцэн тохирогч улсын байнга оршин суугчийн хэлэлцэн тохирогч нөгөө улсад олж буй орлогод хэлэлцэн тохирогч нөгөө улс татвар ногдуулж болно.

23 дугаар зүйл.

Давхар татварыг арилгах

1. Монгол Улсын хувьд давхар татварыг дараах байдлаар арилгана:

а) Энэхүү хэлэлцээрийн заалтын дагуу Сингапур Улсад татвар ногдуулж болох Монгол Улсын байнга оршин суугчийн орлогод Монгол Улс татвар ногдуулахдаа Сингапур улсад төлсөн татвартай нь тэнцүү хэмжээний татварыг тухайн байнга оршин суугчийн орлогод ногдуулсан татвараас хасч тооцно. Гэхдээ тухайн хасагдуулга нь Сингапур Улсад татвар ногдуулж болох орлоготой холбоотой дээрх хасагдуулгыг хийхээс өмнө тооцсон Монголын талын татварын хэмжээнээс хэтэрч болохгүй.

б) Энэхүү хэлэлцээрийн дагуу Монгол Улсад байнга оршин суугчийн орлого Монгол улсад татвараас чөлөөлөгдсөн бол Монгол Улс тухайн оршин суугчийн үлдэх орлогод ногдуулах татварыг тооцохдоо чөлөөлөгдсөн орлогыг оруулж тооцно.

в) "Сингапур улсад төлөх татвар" гэдэгт Сингапур Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой тухайн үед үйлчилж буй хуулиуд болон түүнд цаашид орох өөрчлөлт болон нэмэлтүүдийн дагуу чөлөөлөгдөх болон хөнгөлөгдөх татварыг оруулж тооцно.

2. Сингапур Улсын хувьд давхар татварыг дараах байдлаар арилгана:

а) Энэхүү хэлэлцээрийн заалтын дагуу Монгол Улсад татвар ногдуулж болох Сингапур Улсын байнга оршин суугчийн орлогод Сингапур Улс татвар ногдуулахдаа Сингапураас бусад улсад төлсөн татварыг хасч тооцох тухай өөрийн хуулийн дагуу тухайн байнга оршин суугчийн орлогод ногдуулах Сингапурын татварын хөнгөлөлт болгон Монгол Улсад төлсөн татварыг шууд хасах буюу хасагдуулга хийж тооцно. Монгол Улсын байнга оршин суугч компаниас тус компанийн хувьцааны хөрөнгийн 25-аас багагүй хувийг шууд буюу шууд бусаар эзэмшиж буй Сингапур Улсын байнга оршин суугчид төлсөн ногдол ашгийн хөнгөлөлтийг тооцохдоо тухайн ногдол ашиг төлөгдөж буй ашигт төлсөн Монгол улсын татварыг оруулж тооцно.

б) "Монгол улсад төлөх татвар" гэдэгт Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой тухайн үед үйлчилж буй хуулиуд болон түүнд цаашид орох өөрчлөлт болон нэмэлтүүдийн дагуу чөлөөлөгдөх болон хөнгөлөгдөх татварыг оруулж тооцно.

24 дүгээр зүйл.

Ялгаварлан гадуурхах явдал гаргахгүй байх

1. Хэлэлцэн тохирогч улсын харъяатад татвар төлөлт болон түүнтэй холбоотой бусад шаардлагын хувьд адил нөхцөлд байгаа Хэлэлцэн тохирогч нөгөө улсын харъяатаас өөр буюу илүү хүндрэлтэй татварын нөхцөл болон түүнтэй холбоотой шаардлагуудыг Хэлэлцэн тохирогч нөгөө улсад тавих ёсгүй.

2. Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгжийн хэлэлцэн тохирогч нөгөө улс дахь төлөөлөгчийн газарт ногдуулах татвар нь хэлэлцэн тохирогч нөгөө улсад түүнтэй ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид ногдуулж буй татвараас илүү хүнд нөхцөлтэй байж болохгүй.

3. Энэхүү зүйлийн заалтууд нь хэлэлцэн тохирогч улсад дараах зүйлийг үүрэг болгохгүй. Үүнд:

а) өөрийн байнга оршин суугчид татварын зорилгоор үзүүлдэг аливаа хөнгөлөлт, чөлөөлөлт болон хасагдуулгыг хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугчид мөн үзүүлэх

б) тухайн улсын татварын хуульд заасны дагуу тус улсын байнга оршин суугч бус боловч тухайн улсын харъяат эсвэл адитгах бусад этгээдэд татварын зорилгоор үзүүлж буй хувь хүний хөнгөлөлт,

чөлөөлөлт болон хасагдуулгыг хэлэлцэн тохирогч нөгөө улсын харьяатад мөн үзүүлэх

4. Хэлэлцэн тохирогч улсын аж ахуйн нэгжийн хөрөнгийг Хэлэлцэн тохирогч нөгөө улсын байнга оршин суугч нэг буюу хэсэг этгээд шууд буюу шууд бусаар бүхэлд нь эсвэл хэсэгчлэн өмчилж буюу хянаж байвал Хэлэлцэн тохирогч улс өөрийн адил төрлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн татвар төлөх буюу түүнтэй холбоотой шаардлагаас өөр буюу илүү хүндрэлтэй нөхцөлтэй байж болохгүй.

5. Өөрийн үндэсний бодлого болон шалгуурын дагуу эдийн засаг болон нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн татварын урамшууллуудыг өөрийн харьяатад үзүүлж байвал үүнийг энэхүү зүйлийн дагуу ялгаварлан гадуурхах явдал гаргаж байна гэж үзэхгүй.

6. Энэхүү зүйл нь энэ хэлэлцээрээр зохицуулагдах татваруудад хамаарна.

25 дугаар зүйл.

Харилцан тохиролцох журам

1. Хэрэв этгээд Хэлэлцэн тохирогч аль нэг улс буюу хоёр улс хоёулаа энэхүү Хэлэлцээрт заагдаагүй татвар түүнд ногдуулсан буюу ногдуулж байна гэж үзвэл тухайн Улсуудын дотоодын хууль тогтоомжийн заалтуудыг үл харгалзан өөрийн байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч улсынхаа эрх бүхий байгууллагад гомдлоо гаргаж болно. Гомдлыг энэхүү Хэлэлцээрт заагдаагүй татвар ногдуулж байна гэж анх мэдэгдсэнээс хойш 3 жилийн дотор гаргана.

2. Хэрэв гомдол нь үндэслэлтэй эсвэл нэгдсэн шийдвэрт хүрэх ямар ч боломжгүй бол энэхүү Хэлэлцээрт заагдаагүй татвар ногдуулахгүй байх үүднээс тухайн асуудлыг хэлэлцэн тохирогч нөгөө улсын эрх бүхий байгууллагатай харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийн тулд эрх бүхий байгууллага бүх арга хэмжээ авна. Аливаа нэгдсэн шийдвэрт хүрсэн тохиролцоог Хэлэлцэн тохирогч улсуудын дотоодын хууль тогтоомжид заасан цаг хугацааны хязгаарлалтыг үл харгалзан хэрэгжүүлнэ.

3. Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагууд нь энэхүү Хэлэлцээрийг хэрэглэх болон тайлбарлахад үүсэх аливаа хүндрэлтэй болон эргэлзээтэй асуудлуудыг харилцан тохирох замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Мөн түүнчлэн энэхүү Хэлэлцээрт тусгагдаагүй тохиолдолуудыг давхар татвараас чөлөөлөх асуудлыг тэд харилцан зөвлөлдөж болно.

4. Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллага нь өмнөх заалтуудын талаар тохиролцоонд хүрэх зорилгоор өөр хоорондоо шууд харилцаж болно.

26 дугаар зүйл.

Харилцан мэдээлэл солилцох

1. Хэлэлцэн тохирогч хоёр улсын эрх бүхий байгууллагууд энэхүү Хэлэлцээрт хамрагдах татварын талаарх хоёр улсын хууль тогтоомж болон уг Хэлэлцээрийн заалтуудыг биелүүлэхэд шаардагдах мэдээллийг харилцан солилцож байна. Хэлэлцэн тохирогч улс Хэлэлцэн тохирогч нөгөө улсаас хүлээн авсан мэдээллийг Хэлэлцэн тохирогч улс өөрийн улсын мэдээлэл хадгалах хуулийн дагуу нууцалж зөвхөн энэхүү Хэлэлцээрт хамаарагдах татварын хэмжээг тогтоох буюу хураахтай холбогдсон этгээдүүд, эрх барих байгууллагуудад (шүүх, захиргааны байгууллагыг оролцуулан) мэдэгдэх эрхтэй. Тэдгээр этгээд буюу эрх барих байгууллагууд нь уг мэдээллийг зөвхөн энэхүү зорилгод ашиглана. Түүнчлэн тэд дээрх мэдээллийг олон нийтийн шүүхийн протокол, шүүхийн шийдвэрт тусгаж болно.

2. 1 дүгээр зүйлийн заалтууд нь ямарч тохиолдолд Хэлэлцэн тохирогч улсад дараах үүргийг хүлээлгэх ёсгүй.

а) Хэлэлцэн тохирогч улсуудын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээнд харшлах захиргааны арга хэмжээ хэрэгжүүлэх,

б) Хэлэлцэн тохирогч улсуудын хууль тогтоомж болон захиргааны ердийн үйл ажиллагааны дагуу олж үл болох мэдээлэл буюу баримт бичгээр хангах,

в) Хэлэлцэн тохирогч улсуудын аливаа худалдаа, бизнес, аж үйлдвэр, арилжааны буюу мэргэжлийн нууц алдагдуулах мэдээ болон нийгмийн хэв журамд харшлах мэдээллээр хангах.

27 дугаар зүйл.

Дипломат ба консулын ажилтнууд

Энэхүү Хэлэлцээр нь олон улсын эрх зүйн ерөнхий хэм хэмжээ болон тусгай хэлэлцээрийн заалтуудын дагуу олгогдсон дипломат ба консулын ажилтнуудын санхүүгийн эрх дархыг үл хөндөнө.

28 дугаар зүйл.

Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход өөрийн дотоодын хуулийн дагуу хийх шаардлагатай процедурууд хийгдэж дууссан тухай хэлэлцэн тохирогч улсууд нь бие биедээ дипломат шугамаар мэдэгдэнэ.

2. Энэхүү хэлэлцээр нь сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд түүний заалтууд нь дараах байдлаар үйлчилж эхэлнэ;

а) Монгол Улсад

а/ уг хэлэлцээр хүчин төгөлдөр болсон хуанлийн жилийн дараагийн жилийн 1 дүгээр сарын 1-ны өдөр буюу түүний дараагийн өдрөөс эх үүсвэрт нь суутгасан татвар, төлсөн буюу хөнгөлсөн орлого

б/ уг хэлэлцээр хүчин төгөлдөр болсон хуанлийн жилийн дараагийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүний дараагийн өдрөөс эхлэн орлогод ногдуулах бусад татварууд болон аливаа татварын жилд бий болсон орлого

б) Сингапур Улсад

татвар тодорхойлох жилд ногдуулах татварын хувьд, уг хэлэлцээр хүчин төгөлдөр болсон жилийн дараагийн хоёр дахь хуанлийн жилийн 1 дүгээр сарын 1-ны өдөр буюу түүний дараагийн өдрөөс эхлэн

29 дүгээр зүйл.

Дуусгавар болох

Энэхүү Хэлэлцээрийг Хэлэлцэн тохирогч аль нэг улс цуцлах хүртэл хүчин төгөлдөр мөрдөнө. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дараахь хуанлийн жил дуусахаас 6 сараас өмнө Хэлэлцэн тохирогч аль нэг улс дипломат шугамаар эсвэл бичгээр мэдэгдэж уг Хэлэлцээрийг цуцалж болно. Энэ тохиолдолд энэхүү Хэлэлцээр дор дурдсан татваруудын хувьд хүчин төгөлдөр байхаа болино.

а) Монгол Улсын хувьд:

(1) хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдэл өгсөн хуанлийн жилийн дараагийн жилийн 1 дүгээр сарын 1-ны өдөр буюу түүний дараагийн өдрөөс эх үүсвэрт нь суутгасан татвар, төлсөн буюу хөнгөлсөн орлого

(2) хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдэл өгсөн хуанлийн жилийн дараагийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүний дараагийн өдрөөс эхлэн орлогод ногдуулах бусад татварууд болон аливаа татварын жилд бий болсон орлого

б) Сингапур улсын хувьд;

татвар тодорхойлох жилд ногдуулах татварын хувьд, хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдэл өгсөн жилийн дараагийн хоёр дахь хуанлийн жилийн 1 дүгээр сарын 1-ны өдөр буюу түүний дараагийн өдрөөс эхлэн

Энэхүү Хэлэлцээрт нотолгоо болгож, эрх олгосноор гарын үсэг зурав.

2002 оны 10 дугаар сарын 10 ны өдөр Сингапур хотноо монгол, англи хэлээр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ

**AGREEMENT BETWEEN THE GOVERNMENT OF MONGOLIA AND THE
GOVERNMENT OF THE REPUBLIC OF SINGAPORE FOR THE
AVOIDANCE OF DOUBLE TAXATION AND THE PREVENTION OF
FISCAL EVASION WITH RESPECT TO TAXES ON INCOME**

The Government of Mongolia and the Government of the Republic of Singapore,

Desiring to conclude an Agreement for the avoidance of double taxation and the prevention of fiscal evasion with respect to taxes on income,

Have agreed as follows:

**Article 1
PERSONS COVERED**

This Agreement shall apply to persons who are residents of one or both of the Contracting States.

**Article 2
TAXES COVERED**

1. This Agreement shall apply to taxes on income imposed on behalf of a Contracting State or of its political subdivisions or local authorities, irrespective of the manner in which they are levied.
2. There shall be regarded as taxes on income all taxes imposed on total income or on elements of income, including taxes on gains from the alienation of movable or immovable property.
3. The existing taxes to which the Agreement shall apply are in particular:
 - (a) in Mongolia:
 - (i) the individual income tax;
 - (ii) the corporate income tax, (hereinafter referred to as "Mongolian tax");
 - (b) in Singapore:

the income tax, (hereinafter referred to as "Singapore tax").
4. The Agreement shall apply also to any identical or substantially similar taxes which are imposed after the date of signature of the Agreement in addition to, or in place of, the existing taxes. The competent authorities of the Contracting States shall notify each other of any substantial changes which have been made in their respective taxation laws.

Article 3 GENERAL DEFINITIONS

1. For the purposes of this Agreement, unless the context otherwise requires:

(a) the terms "a Contracting State" and "the other Contracting State" mean Mongolia or Singapore as the context requires;

(b) the term "Mongolia" means when used in a geographical sense all the territory of Mongolia;

(c) the term "Singapore" means the Republic of Singapore;

(d) the term "person" includes an individual, a company and any other body of persons;

(e) the term "company" means any body corporate or any other entity that is treated as a body corporate for tax purposes;

(f) the terms "enterprise of a Contracting State" and "enterprise of the other Contracting State" mean respectively an enterprise carried on by a resident of a Contracting State and an enterprise carried on by a resident of the other Contracting State;

(g) the term "national" means:

(i) any individual possessing the nationality of a Contracting State;

(ii) any legal person, partnership or association deriving its status as such from the laws in force in a Contracting State;

(h) the term "international traffic" means any transport by a ship or an aircraft operated by an enterprise which has its place of effective management in a Contracting State, except when the ship or aircraft is operated solely between places in the other Contracting State;

(i) the term "competent authority" means:

(i) in Mongolia, the Minister of Finance and Economy or his authorised representative;

(ii) in Singapore, the Minister for Finance or his authorised representative.

